

**ХОНДА зөөврийн цахилгаан үүсгүүрийн ашиглалтын заавар техникийн
аюулгүй байдлыг хангах арга хэмжээ:**

1. Хөдөлгүүрийг агаар салхигүй битүү орчинд ажиллуулж огт болохгүй. Шатсан хийнд хордож ухаан алдах, үхэх аюултайг анхаар. Хөдөлгүүрийг агаар салхи сайн ордог газар байрлуулах шаардлагатай.
2. Хөдөлгүүр ажиллаж байгаа үед түлш, бензин нэмж хийх, түүний ойролцоо чүдэнз зурах, тамхи татах зэргийг хатуу хориглоно.
3. Түлш асгарсан бол хөдөлгүүрийг ажиллуулахын өмнө үүнийг бүрэн цэвэрлэж, ууршсан түлшийг сарниул.
4. Бороотой чийглэг орчинд ажиллуулахыг хориглоно.

Ажиллуулахын өмнөх үзлэг шалгалт:

1. Тосны савны тагийг онгойлгож тосны түвшинг шалгана. Тосны түвшин (1) дээд ба (2) доод түвшний хооронд байх ёстой.
2. Агаар шүүгчийн давалчин гайкыг суллаж агаар шүүгчийн тагийг аваад агаар шүүгчийн элементүүдийг гаргаж гэмтсэн цоорсон эсэхийг сайтар харж шалгана. Дурьдсан гэмтэл илэрвэл солих
3. Хувьсах гүйдлийн штепсель-розеткийг салга. Түүнд ямар нэг хэрэгсэл залгагдаагүй байх ёстой. Хэрэв ачаалал буюу цахилгаан хэрэгсэл залгаатай байвал цахилгаан үүсгүүрийг асаахад хүндрэлтэй байх болно.

Хөдөлгүүрийг асаах:

1. Хөдөлгүүрийн хавхлагийг “ON” нээх байрлал дээр тавь.
2. Түлш дамжуулах хоолойн крантыг “ON” нээх байрлал дээр тавь.
3. Агаар дамуулах сувгийг “CLOSED” хаах байрлал дээр тавь.
4. Түлш цацах хөшүүргийг зүүн гар тал руу бага зэрэг хөдөлгөнө.
5. Асаах татуургыг аяархан татаж зуурч эхлэнгүүт нь огцом татна.
6. Хөдөлгүүр халсны дараа агаар дамжуулах сувгийг аажмаар нээх “OPEN” байрлалд тавина.
7. Хөдөлгүүрийг асааж газ өгснөөр Вольтметр 220 в заана.
8. Цахилгаан хэрэгсэлийнхээ утсыг үүсгүүрийн АС штепсельд залгана.
9. Хөдөлгүүрийг унтраахдаа цахилгаан үүсгүүрт холбогдсон төхөөрөмжүүдийг салгана.
10. Түлш цацах хөшүүргийг баруун гар талын эцсийн байрлалд тавина.
11. Хөдөлгүүрийн унтраалгыг “OFF” унтраах байрлал дээр тавь.
12. Түлш дамжуулах хоолойн крантыг “OFF” хаах байрлал дээр тавь.
13. Үүсгүүрийг хамгийн дээд чадлаар (2,2 квт) 30 минутаас илүү хугацаагаар бүү ажиллуул.
14. Хөдөлгүүрийг гэнэт зогсоох шаардлагатай бол унтраалгын “OFF” товчлуурыг дарна.